



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 20 өдөр

Дугаар А/426

Булган сум

Г Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах эрх олгох тухай Г

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан “Шинэ суурьшлын бүсэд гадна дулаан цэвэр усны шугам сүлжээ татах (Баян-Агт сум)” ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан “Ээлт-Өлгий” ХХК-тай 235,563,492 (хоёр зуун гучин таван сая таван зуун жаран гурван мянга дөрвөн зуун ерэн хоёр) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2.Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т, тус хөрөнгийг холбогдох хууль, журам, гэрээний дагуу хүлээн авч данс бүртгэлд бүртгэн, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг Баян-Агт сумын Засаг дарга (Б.Бямбажав)-д тус тус үүрэг болгосугай.

3.Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандарт, зураг, төсвийн дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг “Ээлт-Өлгий” ХХК-ийн захирал (Л.Давааням)-д даалгасугай.

4.Гэрээнд тусгах нөхцөл шаардлагыг хавсралтаар баталж, заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусган хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

5.Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Б.Ариунболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА


Д.ПҮРЭВ-ОЧИР



Sugar Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010586

Аймгийн Засаг даргын 2025 оны
06 дугаар сарын 20-ны өдрийн
А/426 дугаар захирамжийн хавсралт



Гэрээнд тусгах нөхцөл шаардлага

д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Магадалшгүй ажил	3,956,650	Ү.Бямбасүрэн
2	Захиалагчийн техник хяналтын зардал	3,956,650	Ү.Бямбасүрэн
3	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	1,978,325	Ү.Бямбасүрэн
4	Инженер хайгуул, зураг төслийн ажлын дүн	7,700,000	Б.Ариунболд
5	Нормчлолын сан	356,099	Ү.Бямбасүрэн
6	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Б.Ариунболд
7	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	Б.Ариунболд Ү.Бямбасүрэн
8	Гүйцэтгэлийн баталгаа	3 хувь	Б.Ариунболд
9	Ажил гүйцэтгэх хугацаа	Хуанлийн 60 хоног	Ү.Бямбасүрэн